



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх заалт, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3, 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төр, иргэний хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, идэвхжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилгоор гудамж байрны нийтийн эргүүлүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулахыг Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс /Г.Уламбаяр/-т даалгасугай.

2. Сургалтын арга хэмжээний удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын
14-ний өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ГУДАМЖ, БАЙРНЫ НИЙТИЙН
ЭРГҮҮЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЧАДАВХЖУУЛАХ
АРГА ЗҮЙН СҮРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Чингэлтэй дүүргийн гудамж, байрны нийтийн эргүүлүүдийн үйл ажиллагааг чадавхжуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаарх цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, иргэд, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга замын талаар харилцан мэдээлэл авч, шинэлэг санал, санаачлагыг хэрэгжүүлэхэд оршино.

Хугацаа: 2016 оны 03 сарын 21, 22-ны 11⁰⁰ цагт

Хаана: Зэвсэгт хүчний 311 дүгээр анги

Оролцогчид: Чингэлтэй дүүргийн гудамж, байрны нийтийн эргүүлүүд

Сургалтын хөтөлбөр:

11:30-11:40 Нээлт

*Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Д.Бат-Эрдэнэ/*

11:40- 13:00 Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвтэй танилцах

13:00-14:00 Өдрийн хоол

14:00-14:30 Гудамж, байрны нийтийн эргүүлийн анхаарах асуудал

*Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга,
дүүргийн ГХУСЗСЗ-ийн гишүүн Хурандаа П.Батбаатар/*

14:30-15:00 Хулгай, танхай, булаалт, дээрмийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

*Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга,
дүүргийн ГХУСЗСЗ-ийн гишүүн, дэд Хурандаа Б.Нацагдорж/*

15:00-15:30 Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

*/Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга,
дүүргийн ГХУСЗСЗ-ийн гишүүн Хурандаа Я.Жаргалсайхан/*

15:30-16:00 Хог хаягдлын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх арга зам

*/Чингэлтэй дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга,
дүүргийн ГХУСЗСЗ-ийн гишүүн О.Болд/*

16:00-16:30 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж, байрны
нийтийн эргүүлийн анхаарах асуудал

*/Чингэлтэй дүүргийн 1 дүгээр прокурор, хууль цаазын ахлах
зөвлөх Л.Бадралт/*

16:30-17:30 “Хүнлэг нинжин сэтгэл харилцаанаас эхтэй” сэдэвт лекц

/Эрдмийн их сургуулийн хүндэт доктор Б. Гэрэл /

17:30 Хаалт

Үр дүн: Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлын үр нөлөө дээшилж, иргэдийн идэвх санаачлагад суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, иргэд, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжинэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.13 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 61 дүгээр сургууль байгуулагдсаны 40 жилийн ойг 2016 оны 10 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойг угтаж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1993 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуй нэгжийн ой тэмдэглэх журам”-ын 4, 5, 6 дугаар заалтуудыг хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн тодорхой ажлуудыг зохион байгуулж, хийсэн ажлаа хамт олондоо тайлагнаж, ойн арга хэмжээг бэлтгэл зохион байгуулалт сайтай тэмдэглэхийг 61 дүгээр сургуулийн захирал /А.Мөнхчимэг/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хариуцлага тооцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 13 дугаар зүйлийн 13.8.1 дэх заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Чимэдбатын Дэчингалсангийн 2015 оны мэдүүлгийг нөхөн гаргуулж, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын даргын урамшуулал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн даргын урамшууллыг тус тус 20 хувиар 3 сарын хугацаагаар бууруулахаар шийдвэрлэсүгэй.

2. 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Цэрэндашийн Эрдэнэбаярт сануулах арга хэмжээ авахаар шийдвэрлэсүгэй.

3. Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд, зохих журмын дагуу гаргаж байх талаар шаардлага хүргүүлж ажиллахыг Хурлын Ажлын албаны мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах эрх бүхий албан тушаалтан /Г.Ундрал/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ